



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 5/37

Дадал сум

О.Баярмааг нүүдлийн гэр цэцэрлэгийн
багшийн туслахаар түр томилох тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 8.2, Сургуулийн Өмнөх болон Ерөнхий Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1,3, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.5, 64.4, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Балж багийн Галттай хэсэгт малчдын хүүхдүүдийг хамруулах зуны Хувилбарт сургалт, нүүдлийн гэр цэцэрлэгт (Очирхуягийн Баярмаа)-г 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс тус бүлгийн багшийн туслахаар 21 хоногийн хугацаатай томилон ажиллуулсугай.

2. Багш С.Чулууннямтай хамтран тус бүлэгт эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хамрагдаж байгаа хүүхэд бүрийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллахыг (О.Баярмаа)-д үүрэг болгосугай.

3. Нүүдлийн гэр цэцэрлэг ажиллуулахтай холбоотой шаардлагатай цэвэрлэгээ болон хүнсний материалыг хангаж, хүлээлгэж өгч, хариуцаж ажиллахыг нярав (М.Ичинхорлоо)-д даалгасугай.

4. (О.Баярмаа)-гийн цалинг ТҮБД-1 1.283.000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөгөөр тооцож, холбогдох нэмэгдлүүдийг олгохыг нягтлан бодогч (Э.Мөнхмаа)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ Н.ОДГАРАВ

